



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/36

Номгон

Г Малын шилжилт хөдөлгөөнийг хориглох
тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Зөрчлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9.2, 13.9.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гадны аймгаас отор нүүдэл, үйлдвэрлэл худалдаа, үржлийн болон бусад зорилгоор салаа туурайтан амьд мал, амьтан зөөвөрлөж тээвэрлэн тус аймгийн нутаг дэвсгэрт байршуулахыг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хориглосугай.

2. Адуун сүргийг өөрийн аймаг, сумын нутаг дэвсгэрт нэвтрүүлэхдээ Мал эмнэлгийн гэрчилгээнд үндэслэн нийлүүлгийн өвчин, хачгийн халуун, адууны ям зэрэг өвчнүүдийн шинжилгээнд хамруулж, халдваргүйтгэл хийлгэн нэвтрүүлэхийг Мал эмнэлгийн газар (Л.Оюун-Эрдэнэ), сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Малын ашиг шимийг нэмэгдүүлэх, цөм сүрэг бий болгох, өсвөр хээлтүүлэгч өсгөн бойжуулах, худалдан борлуулах зэрэг ажлыг аймаг, орон нутгийн нөөц боломжид тулгуурлан зохион байгуулж, өөрийн аймгийн баталгаажсан үүлдэр, омгийн малыг сайжруулагчаар ашиглахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (У.Балжинням), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Малчид, мал бүхий иргэдэд мал, амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг чангатгаж халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай сэрэмжлүүлж ард иргэдэд хүргэж, мал, амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Л.Оюун-Эрдэнэ), Хүнс, хөдөө аж ахуйн газар (У.Балжинням), Цагдаагийн газар (Б.Мөнхбаяр), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.



Д.МӨНХСАЙХАН

642310095

D:\2023 он\захирамж-2023\Захирамж-2023 он.docx